

Нэг. Өнөөгийн байдал.....	2
Хоёр. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын талаар.....	2
Гурав. Орлого, зарлага, ашигт ажиллагааны талаар.....	4
Дөрөв. Активын чанар, зээлийн үйл ажиллагааны талаар.....	
4.1 Активын талаар.....	5
4.2 Активын багцын чанар.....	6
Тав. Нийт эх үүсвэрийн бүтцийн талаар.....	
5.1 Нийт эх үүсвэрийн талаар.....	6
5.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц.....	7
Долоо. Дүгнэлт.....	7

Хавсралтууд

ХЗХ-уудын нэгдсэн хураангуй тэнцэл

Актив, Пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан

Активын чанарын болон хамгаалалтын үзүүлэлтийн тайлан

Үр ашигтай санхүүгийн бүтцийн тайлан

Активын чанарын үзүүлэлтийн тайлан

Өгөөж, зардлын хувь хэмжээний тайлан

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан

Жигнэсэн дундаж хүүгийн судалгаа

ХЗХ-дуудын нэгдсэн дэлгэрэнгүй тэнцэл /*нийт ХЗХ-дуудаар*/

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2009 ОНЫ I УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА


2009.05.20

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны тогтоолоор 7 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 2 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 214 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээрээс 190 буюу нийт ХЗХ-дын 88.8 хувь нь зохих журмын дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайланг ирүүлсэн, 24 буюу нийт ХЗХ-дын 11.2 хувь нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй тул өмнөх улирлаар нь нэгтгэлд хамруулснаар ХЗХ-д 100.0 хувь санхүүгийн нэгтгэлд хамрагдлаа.



Тайлант улиралд нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өссөн байна.



ХОЁР. ОРОН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ХОРШООДЫН ТАЛААР

Орон нутагт 112 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ХЗХ-дын 52.3 хувийг, тэдгээрийн нийт актив 6,508.148.4 мянган төгрөг нь нийт активын 15.4 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 4,975,705.3 мянган төгрөг нь нийт олгосон зээлийн 15.1 хувийг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 3,332,634.8 мянган төгрөг нь нийт хадгаламжийн 11.6 хувийг, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 1,745,006.5 мянган төгрөг нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 24.9 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант улиралд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-д 13,391 гишүүнтэй байгаа нь нийт хоршоодын гишүүдийн 49.5 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-г байршлын хувьд авч үзвэл дараах байдалтай байна.



ГУРАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант улиралд нийт орлого өмнөх оны мөн үеэс 2,028,567.0 мянган төгрөгөөр буюу 71 хувиар өсч 4,885,276.7 мянган төгрөгт хүрсэн ба нийт орлогын бүтцийн өөрчлөлт дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2008.I УЛИРАЛ	ХУВЬ	2009.I УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
I	ХҮҮГИЙН ОРЛОГО	2,572,748.00	90.1%	2,791,992.33	57.2%	219,244.33
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	2,155,465.04	75.5%	2,649,701.19	54.2%	494,236.15
	Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	32,237.73	1.1%	51,273.42	1.0%	19,035.69
	Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	377,349.04	13.2%	86,007.35	1.8%	(291,341.69)
	Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	2,073.44	0.1%	764.45	0.0%	(1,308.99)
	Бусад хүүгийн орлого	5,622.75	0.2%	4,245.91	0.1%	(1,376.84)
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	84,258.73	2.9%	160,075.82	3.3%	75,817.09
	Элсэлтийн хураамж	4,544.15	0.2%	2,901.35	0.1%	(1,642.80)
	Гишүүний татвар	6,040.82	0.2%	12,667.39	0.3%	6,626.57
	Үйлчилгээний хураамж	28,135.74	1.0%	13,596.20	0.3%	(14,539.54)
	Үйл ажиллагааны бусад орлого	45,538.02	1.6%	130,910.88	2.7%	85,372.86
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	197,828.30	6.9%	1,929,816.43	39.5%	1,731,988.13
	Торгуулийн орлого	-	0.0%	1,491.33	0.0%	1,491.33
	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	4,493.25	0.2%	4,985.57	0.1%	492.32
	ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	-	0.0%	-	0.0%	-
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	23,372.74	0.8%	1,726,265.26	35.3%	1,702,892.52
	Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	153,597.61	5.4%	50,857.76	1.0%	(102,739.85)
	Бусад орлого	10,929.58	0.4%	101,254.01	2.1%	90,324.43
	Онцгой шинжтэй орлого	5,435.12	0.2%	44,962.50	0.9%	39,527.38
IV	ЕРДИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО	(735.47)	0.0%	3,216.82	0.1%	3,952.29
	Ердийн бус орлого	1,874.68	0.1%	3,392.14	0.1%	1,517.46
V	НИЙТ ОРЛОГО:	2,856,709.71	100.0%	4,885,276.72	100.0%	2,028,567.01

Өнгөрсөн оны I улирлын байдлаар нийт орлогын 90.1 хувийг хүүгийн орлого эзэлж, орлогын гол эх үүсвэр болж байсан бол 2009 оны I улирлын байдлаар нийт орлогын 57.2

хувийг хүүгийн орлого, 35.3 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого эзэлж байгаа нь өнгөрсөн улиралд гадаад валютын ханшийн хэлбэлзлээс ХЗХ-д үйл ажиллагааны бус орлого олсон байгааг илтгэж байна.

Нийт зардал өмнөх оноос 1,742,757.6 мянган төгрөгөөр буюу 70.7 хувиар өсч 4,208,200.5 мянган төгрөгт хүрсэн ба нийт зардлын бүтцийн өөрчлөлт дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2008.1 УЛИРАЛ	ХУВЬ	2009.1 УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
I	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,689,288.89	68.5%	1,646,822.18	39.1%	(42,466.71)
	Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	864,228.83	35.1%	627,429.03	14.9%	(236,799.80)
	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	732,369.60	29.7%	902,821.53	21.5%	170,451.93
	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	61,077.95	2.5%	38,512.02	0.9%	(22,565.93)
	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	30,357.30	1.2%	74,367.30	1.8%	44,010.00
	Бусад хүүгийн зардал	1,255.21	0.1%	3,692.29	0.1%	2,437.08
II	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	86,006.58	3.5%	285,456.16	6.8%	199,449.58
	Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	87,532.14	3.6%	281,634.34	6.7%	194,102.20
	Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	5.10	0.0%	905.08	0.0%	899.98
	Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	619.50	0.0%	1,900.62	0.0%	1,281.12
	Бусад эрсдэлийн зардал	(2,150.16)	-0.1%	1,016.13	0.0%	3,166.29
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	614,351.67	24.9%	629,545.92	15.0%	15,194.25
	Боловсон хүчний зардал	298,627.53	12.1%	326,748.21	7.8%	28,120.68
	Бусад төрлийн зардал	315,724.14	12.8%	302,797.70	7.2%	(12,926.44)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	21,819.89	0.9%	1,608,332.35	38.2%	1,586,512.46
	Торгуулийн зардал	2,463.10	0.1%	1,772.98	0.0%	(690.12)
	Ногдол ашгийн зардал	1,404.16	0.1%	4,006.34	0.1%	2,602.18
	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	-	0.0%	349.48	0.0%	349.48
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	10,444.59	0.4%	1,338,412.72	31.8%	1,327,968.13
	Үйл ажиллагааны бус бусад зардал	7,508.04	0.3%	263,790.83	6.3%	256,282.79
V	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	2,610.17	0.1%	175.32	0.0%	(2,434.85)
VI	ТАТВАРЫН ЗАРДАЛ	51,365.70	2.1%	37,868.59	0.9%	(13,497.11)
VII	НИЙТ ЗАРДАЛ	2,465,442.90	100.0%	4,208,200.52	100.0%	1,742,757.62

Нийт зардлын 39.1 хувь нь хүүгийн зардал, 15 хувь нь боловсон хүчний холбогдолтой зардал, 38.2 хувь нь гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал тус тус эзэлж байна. Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардлын өсөлт нь нийт зардлын өсөлтийн гол шалтгаан болсон байна.

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2008-1 УЛИРАЛ	2009-1 УЛИРАЛ	ӨӨРЧЛӨЛТ
I НИЙТ ОРЛОГО	2,856,709.71	4,885,276.72	2,028,567.01
II НИЙТ ЗАРДАЛ	2,465,442.90	4,208,200.52	1,742,757.62
ТАТВАРЫН ДАРААХЬ ЦЭВЭР АШИГ	391,266.82	677,076.20	285,809.38

Тайлант улиралд 138 ХЗХ буюу нийт ХЗХ-ны 64.5 хувь нь ашигтай ажилласан ба тэдгээрийн нийт ашиг 1,075,184.3 мянган төгрөг байна. Ашигтай ажилласан ХЗХ-дын арифметик дундаж ашиг 7,791.2 мянган төгрөг байна.

Харин 76 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 35.5 хувь нь 398,108.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас 60.1 хувь буюу 238,930.2 мянган төгрөг нь “Сидан” /58,075.7 мянган төгрөг/, “Мон инвест” /60,132.4 мянган төгрөг/, “Кредит юнион монгол” /48,167.8 мянган төгрөг/, “Монкорд” /22,900.5 мянган төгрөг/, “Финком” /38,457.7 мянган төгрөг/, “Монгол газар гоулд” /11,196.1 мянган төгрөг/ зэрэг ХЗХ-дын алдагдал байна.

Алдагдалтай ажилласан шалтгааныг нь тодруулж авч үзэхэд татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн өртөг өндөр, зээлийн чанар муудсан, гадаад валютаар зээл олгодог ХЗХ-дод гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал өндөр зэрэг нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын талаар

Тайлант улиралд нийт активын бүтэц дараах байдалтай байна. Үүнд

/мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2008.I УЛИРАЛ	Нийт активт эзлэх хувь	2009.I УЛИРАЛ	Нийт активт эзлэх хувь	ӨӨРЧЛӨЛТ
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	43,337,758.44	96.7%	40,782,838.05	96.5%	(2,554,920.39)
I МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,134,968.01	24.8%	6,590,406.26	15.6%	(4,544,561.75)
1. Касс дахь бэлэн мөнгө	1,217,346.53	2.7%	1,592,576.40	3.8%	375,229.87
2. Банкинд байршуулсан харилцах	486,294.27	1.1%	2,154,351.98	5.1%	1,668,057.71
3. Банкинд байршуулсан хадгаламж	9,426,297.71	21.0%	2,808,016.29	6.6%	(6,618,281.42)
4. Бусад байгууллагад байршуулсан харилцах	5,029.50	0.0%	-	0.0%	(5,029.50)
5. Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	-	0.0%	35,461.60	0.1%	35,461.60
II ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	29,386,442.84	65.6%	31,294,718.56	74.0%	1,908,275.72
6. Нийт зээл	30,602,751.89	68.3%	33,007,607.33	78.1%	2,404,855.44
6.1. Хэвийн зээл	28,077,348.55	62.7%	28,698,747.30	67.9%	621,398.75
6.2. Хугацаа хэтэрсэн зээл	1,223,284.35	2.7%	1,907,687.06	4.5%	684,402.71
6.3. Чанаргүй зээл	1,302,118.99	2.9%	2,401,172.97	5.7%	1,099,053.98
Хэвийн бус	309,541.49	0.7%	725,084.40	1.7%	415,542.91
Эргэлзээтэй зээл	190,055.21	0.4%	691,602.09	1.6%	501,546.88
Муу зээл	802,522.29	1.8%	984,486.48	2.3%	181,964.19
6.4 (Зээлийн эрсдэлийн сан)	1,216,309.05	2.7%	1,712,888.77	4.1%	496,579.72
III АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,388,771.42	5.3%	2,336,835.20	5.5%	(51,936.22)
7. Байгууллага, хүмүүсээс авах авлага	399,040.64	0.9%	414,601.04	1.0%	15,560.40
7.1 (Байгууллага, хүмүүсээс авах авлага эрсдлийн сан)	29,387.82	0.1%	45,278.96	0.1%	15,891.14
8. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,019,118.60	4.5%	1,967,513.12	4.7%	(51,605.48)
IV БУСАД ХӨРӨНГӨ	95,087.80	0.2%	147,069.30	0.3%	51,981.50
9. Материал үнэ бүхий зүйл	47,236.82	0.1%	108,449.73	0.3%	61,212.91
10. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	22,286.97	0.0%	20,873.81	0.0%	(1,413.16)
11. Бусад актив	25,564.01	0.1%	17,745.75	0.0%	(7,818.26)
V ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	332,488.37	0.7%	413,808.73	1.0%	81,320.36
12. Өмчлөх бусад хөрөнгө	333,855.89	0.7%	444,258.87	1.1%	110,402.98
13. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	1,367.52	0.0%	30,450.15	0.1%	29,082.63
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,478,082.67	3.3%	1,481,994.15	3.5%	3,911.48
VI ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,336,820.28	3.0%	1,362,221.75	3.2%	25,401.47
14. Үндсэн хөрөнгө	1,768,486.63	3.9%	1,854,036.93	4.4%	85,550.30
15. (Үндсэн хөрөнгийн элэгдэл)	431,666.35	1.0%	491,815.18	1.2%	60,148.83
VII БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	141,262.39	0.3%	119,772.40	0.3%	(21,489.99)
16. Биет бус хөрөнгө	28,917.66	0.1%	34,666.84	0.1%	5,749.18
17. Бусад	112,344.73	0.3%	85,105.56	0.2%	(27,239.17)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	44,815,841.11	100.0%	42,264,832.20	100.0%	(2,551,008.91)

Нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 2,551,008.9 мянган төгрөг буюу 5.7 хувиар буурсантай холбоотойгоор нийт актив буурчээ. Хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 35,851,085.2 мянган төгрөг болж нийт активт эзлэх хувийн жин нь 84.8 хувь болжээ.

4.2 Активын багцын чанар

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн бүтэц дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

АКТИВ	2008.I УЛИРАЛ	ХУВЬ	2009.I УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	29,386,442.84		31,294,718.56		1,908,275.72
Нийт зээл	30,602,751.89	100.0%	33,007,607.33	100.0%	2,404,855.44
1. Хэвийн зээл	28,077,348.55	91.7%	28,698,747.30	86.9%	621,398.75
2. Хугацаа хэтэрсэн зээл	1,223,284.35	4.0%	1,907,687.06	5.8%	684,402.71
3. Чанаргүй зээл	1,302,118.99	4.3%	2,401,172.97	7.2%	1,099,053.98
Хэвийн бус	309,541.49	1.1%	725,084.40	2.1%	415,542.91
Эргэлзээтэй зээл	190,055.21	0.6%	691,602.09	2.1%	501,546.88
Муу зээл	802,522.29	2.6%	984,486.48	3.0%	181,964.19
4 (Зээлийн эрсдэлийн сан)	(1,216,309.05)		(1,712,888.77)		(496,579.72)

Чанаргүй зээлийн үзүүлэлтүүдийг 2008 оны I улиралтай харьцуулахад 1,099,053.9 мянган төгрөг буюу 84.4 хувиар өсч нийт зээлийн багцад эзлэх хувь нь 7.2, нийт активт эзлэх хувь 5.7 болж өсчээ. Зээлийн чанар муудаж байгаа нь иргэдийн төлбөрийн чадвар муудаж дэлхийг хамарсан санхүү эдийн засгийн тогтворгүй байдал нөлөөлсөн байж болох талтай байна.

Мөн хоршооны удирдлагын чадвар ядмаг, санхүүгийн менежментийн түвшин муу, дотоод хяналтын үр өгөөж тааруу, ажилтнуудын ажил хэрэгч ур чадвар хангалтгүй зэрэг үзүүлэлтүүдээс зээлийн чанар муудаж байна.

ТАВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

5.1 Нийт эх үүсвэрийн талаар

2009 оны I улиралд нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц дараах байдалтай байна.


/мянган төгрөгөөр/

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2007.IV УЛИРАЛ	ХУВЬ	2008.IV УЛИРАЛ	ХУВЬ	ӨӨРЧЛӨЛТ
1. ӨР ТӨЛБӨР	35,776,261.44	79.8%	31,765,962.08	75.2%	(4,010,299.36)
ХАДГАЛАМЖ	31,570,530.82	70.4%	28,627,894.26	67.7%	(2,942,636.56)
1. Хугацаагүй	2,305,926.20	5.1%	1,965,104.56	4.6%	(340,821.64)
2. Хугацаатай	29,264,604.62	65.3%	26,662,789.70	63.1%	(2,601,814.92)
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,919,546.27	4.3%	658,274.66	1.6%	(1,261,271.61)
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,919,546.27	4.3%	655,929.51	1.6%	(1,263,616.76)
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	-	0.0%	2,345.14	0.0%	2,345.14
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,176,312.19	4.9%	1,970,035.98	4.7%	(206,276.21)
5. Татварын төлөх өглөг	52,513.71	0.1%	42,843.85	0.1%	(9,669.86)
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,922,352.91	4.3%	1,631,533.08	3.9%	(290,819.83)
7. Өглөг	80,593.57	0.2%	209,538.96	0.5%	128,945.39
8. Бусад пассив	120,851.99	0.3%	86,120.09	0.2%	(34,731.90)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	109,872.16	0.2%	509,757.19	1.2%	399,885.02
9. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	109,872.16	0.2%	509,757.19	1.2%	399,885.02
10. Урт хугацаат төслийн санхүүжилт	-	0.0%	-	0.0%	-
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9,039,579.66	20.2%	10,498,870.12	24.8%	1,459,290.46
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,394,042.10	16.5%	6,994,315.82	16.5%	(399,726.28)
11. Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,394,042.10	16.5%	6,994,315.82	16.5%	(399,726.28)
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	1,645,537.56	3.7%	3,504,554.30	8.3%	1,859,016.75
12. Нөөцийн сан	638,668.54	1.4%	838,785.63	2.0%	200,117.09
13. Дахин үнэлгээний сан	20,465.33	0.0%	375,740.85	0.9%	355,275.51
14. Нийгмийн хөгжлийн сан	102,842.28	0.2%	128,974.91	0.3%	26,132.63
15. Бусад сангууд	152,716.06	0.3%	133,272.42	0.3%	(19,443.64)
16. Хандив, тусламж	24,989.02	0.1%	52,997.38	0.1%	28,008.36
17. Бусад өмч	(14,728.02)	0.0%	27,037.92	0.1%	41,765.93
18. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	391,266.82	0.9%	677,076.20	1.6%	285,809.38
19. Хуримтлагдсан ашиг/алдагдал	329,317.53	0.7%	1,270,669.00	3.0%	941,351.48
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	44,815,841.09	100.0%	42,264,832.20	100.0%	(2,551,008.89)

Хувь нийлүүлсэн хөрөнгө 399,726.3 мянган төгрөг буюу 5.4 хувиар, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 2,942,636.6 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар тус тус буурсантай холбоотойгоор нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 2,551,008.9 мянган төгрөг буюу 5.7 хувиар буурчээ. Хадгаламж буурч байгаа гол шалтгаан нь бэлэн мөнгөний хомсдолд орсон иргэд хадгаламж хэлбэрээр байршуулсан мөнгийг буцаан татаж байна гэж таамаглаж байна.

5.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

ХЗХ-дыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр нь ангилж үзвэл дараах байдалтай байна.



ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ХЗХ-дын нийт актив 42,264.83 сая төгрөг нь банкны салбарын нийт активын /*банкны салбарын нийт актив 3,858,374.2 сая төгрөг*/ 1.09 хувь, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 33,007.6 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт олгосон зээлийн /*2,757,727.5 сая төгрөг*/ 1.2 хувь, нийт хадгаламжийн үлдэгдэл 28,627.9 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт хадгаламжийн үлдэгдлийн /*1,682,707.8 сая төгрөг*/ 1.7 хувьтай тус тус тэнцэж байна.

Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг ХЗХ хэрхэн хангаж байгаад дүгнэлт хийхэд дараах байдалтай байна.

1. Зарим ХЗХ-д зээлийн болзошгүй эрсдлээс хамгаалах санг илүү байгуулсан /нэгтгэлийн дүнгээр 105,945.8 мянган төгрөгөөр илүү байгуулсан/ нь □Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам□-д Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 125/80 тоот хамтарсан тушаалаар нэмэлт өөрчлөлт орж, зээлийг ангилах хугацаа, зээлийн эрсдэлийн сан байгуулах хувь хэмжээг өөрчилсөний дагуу зээлийг ангилаагүй,

2. Зээлийн эргэн төлөлт удааширсан, хоршооны удирдлагын чадвар, санхүү менежментийн үр өгөөж муу зэргээс хамаарч ХЗХ-дын зээлийн чанар муудсанаас /нэгтгэлийн хувьд 7.3 хувь/ чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл, нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй гэсэн харьцааг ХЗХ-д хангаагүй,

3. Хоршооны хоршоологчдын өмч /*хоршоологчдын өмч гэдэг нь хоршооны өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хассаны дараах хөрөнгө*/ нь нийт активын 10 хувиас дээш байна гэсэн боловч тайлангаар 8.3 хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна.

Үүний тулд татварын дараах цэвэр ашгаас нөөцийн сан байгуулах асуудалд онцгой хяналт тавих замаар хоршоологчдын өмчийг нэмэгдүүлэх, зайнаас тавих хяналтыг чанаржуулах, тайлангийн хариугаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах зорилгоор захиргааны хариуцлага ногдуулах асуудлыг чангатгах шаардлагатай байна.

Цаашид ХЗХ-ны үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, санхүү, төлбөрийн чадварыг тогтворжуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, хоршооны гишүүд, удирдлагад зориулсан сургалтыг эрчимжүүлэх /ялангуяа орон нутаг дахь ХЗХ-дод/, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх, ажиллах боловсон хүчний ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР